



Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:

1. Удирдлага, зохион байгуулалт
2. Биеийн тамирын хэлтсийн үйл ажиллагаа
3. Спортын хэлтсийн үйл ажиллагаа
4. Байгууллага орчноо тохижуулах
5. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгаа
6. Мэдээлэл, сурталчилгаа
7. Төсвийн хөрөнгийн зарцуулалт ил тод байдал

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны үйл ажиллагааны тайлан

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Аймгийн засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/86 тоот захирамжаар баталсан бүтцийн дагуу Төрийн захиргааны хэлтэс, Биеийн тамирын хэлтэс, Спортын хэлтэс гэсэн 3 хэлтэстэйгээр 22 орон тоотойгоор үйл ажиллагаа явууллаа.

Байгууллагын үйл ажиллагаанд “Алсын хараа 20250”, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, ССАЖЗЯ, БТСУХ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж ажиллаа.

Хоёр. Биеийн тамирын хэлтсийн үйл ажиллагааны талаар:

Биеийн тамирын хэлтэс нь Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх, биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, аймгийн хэмжээний биеийн тамирын талаарх мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулж, хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулах зэрэг 1 зорилтын хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж ажилласан. Арга хэмжээг иргэдийн нас, биеийн онцлогт тулгуурлан зохион байгуулж байна. Үүнд

- ✓ Өвлийн биеийн тамирын арга хэмжээ
- ✓ Өсвөр үеийнхэний биеийн тамир
- ✓ Ахмадын биеийн тамир
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир
- ✓ Үндэсний спортыг сурталчлах арга хэмжээ
- ✓ Сумдын биеийн тамирын арга хэмжээ
- ✓ Сургалт сурталчилгаа, мэдээлэл

Нийт 2 аян, 88 арга хэмжээ, сургалт мэдээллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 25384 иргэн хамрагдсан байна.

2.1 Эрүүл монгол хүн хөтөлбөрийн хүрээнд:



Аймгийн ЭМГ-тай хамтран Ажлын байрны “Түмэн дасгал, “Алхахад цаг гаргая” 2 сарын аяныг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд зохион байгуулж аяны хүрээнд Улаан Уул, Гашууны голын чиглэлд алхаж буй иргэдийг сурталчлах, 10000 алхалтыг хэмжигч

“Strava” апп-ийг татаж цахим уралдаанд оролцох талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, алхалтад уриалсан нөлөөллийн арга хэмжээг БТСГ-ын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлах, идэвхжүүлэх, ажлыг тасралтгүй зохион байгуулсан.

Аянд оролцогчид “Өглөөний дасгал, алхалт гүйлтийг хэвшүүлье” цахим группт өдөр бүр мэдээлэл оруулж, олон нийтэд сурталчилж ажиллаа.

Аяны үр дүнд алхалтын арга хэмжээнд 12 сумын давхардсан тоогоор 4250 хүн, ажлын байрны дасгалын арга хэмжээнд 75 байгууллагын 6000 гаруй иргэдийг хамруулсан.

Аймгийн Дугуйн холбоотой хамтран Улаангом-Улиастай-Улаангом”- 735 км-ын аялалыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 10 дугуйчин оролцож Завхан аймгийн БТСГ-ын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан ажилласан. 1000,0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



“Цаст Хархираа” уулын холбоо ТББ-тай хамтран **“УВС 100”**, Монголын уулчдын 70, Увс аймгийн уулчдын 65 жилийн ойн хүрээнд Хархираа д.т.д 3300 м-ын өндөрлөгт алхалт, авиралт зохион байгууллаа. Энэхүү алхалт, авиралтад 15 баг, байгууллагын 64 иргэн оролцсон байна.



Монголын шугаман бүжгийн холбоо, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран Баруунтуруун, Хяргас, Малчин сумын соёлын төвтэй хамтран ЭРҮҮЛ МЭНДИЙН ДАСГАЛ,ШУГАМАН БҮЖИГ"-ийн сургалтыг зохион байгуулж, 300 гаруй , иргэд хамрагдаж, өдөр бүр тогтмол хичээллэж байна.

2.2 Өвлийн биеийн тамирын арга хэмжээ

“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд Улаангом сумын ЗДТГ,ЭМГ, Улаангом сумын Соёлын төв хамтран зохион байгуулсан “ МӨНГӨН ӨВӨЛ” цасны баярын арга хэмжээнд нийт 43 байгууллага, 2000 гаруй ажилан, албан хаагч, иргэд хөдөлмөрчид хамрагдаж, цасны сумо, үндэсний хувцасны үзүүлбэр, цасан дээрх бүжиг, хөгжилтэй буухиа, олс таталт, нисдэг таваг зэрэг спортын 7 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж явууллаа.



Улаангом, Цагаанхайрхан, Баруунтуруун, Өмнөговь, Давст, Малчин, Хяргас сумдад Мөсний баяр, Цасны баяр нийт 9 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж 4641 иргэн хамрагдсан байна.



БНХАУ-ын Шинжаан Уйгарын өөртөө засах орны Алтай аймгийн захиргаа, Спортын товчоо, Соёл спорт, аялал жуулчлалын газраас санаачлан зохион байгуулж буй "Алтай уулыг тойрсон бүс нутаг"-ийн өвлийн 2-р наадамд Увс аймгаас 8 тамирчин, 2 дасгалжуулагч, албаны 3 хүний хамт оролцсон.





аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулсан.

Аймгийн ЗДТГ, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран “Хүүхэд бүр ялагч-Хүн бүр хүүхэд хамгаалагч” уриатай хүүхдийн марафоныг зохион байгууллаа. Марафон Маршал Ю. Цэдэнбалын талбай дээр өгөгдсөн маршрутын дагуу 3 өсвөрийн 3 нас, Гэр бүлийн марафон ангилалаар амжилттай зохион байгуулагдаж “Хүүхэд бүр ялагч” гэж тодотгохыг зорьлоо. Оролцсон хүүхэд бүрт батламж, дурсгалын тэмдэг гардууллаа. Марафонд нийт 400 гаруй хүүхэд оролцсон.



Монголын Үндэсний Олимпын хороо, Мюнхен Олимпын зөвлөлтэй хамтран олимпын үзлэ санааг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, өсвөр үеийнхэнд олимпын боловсрол олгох чиглэлээр “**OLYMPIC DAY**”, “**LET’S MOVE**” кросс гүйлтийн тэмцээнийг зохион байгууллаа.

Арга хэмжээ 3 насны ангилалаар явагдаж 150 гаруй бяцхан тамирчид оролцож бүх тамирчдад гарын бэлэг гардууллаа.



Өсвөрийн бөхчүүдийн дунд "Өнгөлөг трейд ХХК-ний нэрэмжит 64 бөхийн, Улаангом сумын ИТХ-ын нэрэмжит өсвөрийн хүүхдийн барилдаан зэрэг нийт 15 удаагийн арга хэмжээнд 3147 өсвөрийн бөхчүүд хамрагдан оролцсон.



Монгол улсын их хурлын дарга Д. Амарбаясгалангийн ивээл дор зохион байгуулагдаж буй "TOUR OF MONGOLIA -2025" 26 дахь удаагийн монголын дугуйн олон өдрийн тэмцээний нэрэмжит хүүхдийн дугуйн уралдааныг Увс аймгийн хүүхэд багачуудын дунд 6 насны ангилалд зохион байгуулж аваргуудыг тодрууллаа. Ангилал тус бүрт тэргүүн байр эзэлсэн тамирчдад унадаг дугуй бэлгэллээ.



2.4 Ахмад настны биеийн тамир

Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл насжилтыг дэмжих, мэдээлэл сургалтыг настнуудад хүргэх зорилгоор аймгийн Ахмадын хороо, ЭМГ, Сагил, Давст сум, Улаангом сумын 2 багийн 200 гаруй ахмадуудад “Эрүүл насжилтын төлөө хамтдаа” сургалтыг хамтран зохион байгуулсан.

Аймгийн Ахмадын хороотой хамтран шатар, даам, волейболын төрлөөр арга хэмжээ зохион байгуулж 160 гаруй ахмадууд оролцсон.

Аймаг, сумдын биеийн тамирын арга зүйчтэй хамтран 15 удаагийн арга хэмжээнд 993 ахмад настныг оролцуулсан байна.

2.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир

Монголын Тусгай Олимпын хороотой хамтран **“БОЛОМЖИЙГ БҮГДЭД”** Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй, тусгай олимпын чиглэлээр эмч мэргэжилтэн, багш, эцэг хамгаалагч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Сургалтад сумдын эрүүл мэндийн төвийн их эмч, халамжийн байцаагч, ЕБС-ийн биеийн тамирын багш, СӨБ-ийн арга зүйч багш нар, нийгмийн ажилтнууд болон эцэг эх, асран хамгаалагч нарын төлөөлөл 130 хүн хамрагдлаа. Мөн тусгай хэрэгцээт хүүхдүүдийн дунд тусгай олимпын спортын 3 төрлийн үзүүлэх тоглолт, тэмцээн, уралдааныг зохион байгуулж, 60 гаруй хүүхдүүд хамрагдаж оролцлоо. Энэхүү арга хэмжээний сургалтад 130,

тусгай олимпын 3 төрлийн тэмцээнд 60 хүүхэд, эмчийн үзлэгт 40 хүүхдийг тус тус хамруулсан.

Арга хэмжээг зохион байгуулахад Увс аймгийн ЗДТГ, ХХҮГ, ЭМГ, Насан туршийн суралцахуйн төв, Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Монголын Тусгай олимпын хороо хамтран ажиллаа. Арга хэмжээний зардалд ХБИ-нийг дэмжих төсөл, арга хэмжээний зардлаас 5000,0 төгрөг санхүүжүүлэв.



Монголын Хүүхдийн спортын 8 дугаар наадмын Тусгай хөнгөн атлетикийн төрөлд 2 сурагчийг асран хамгаалагчийн хамтаар оролцуулсан.

Монголын Бүх ард түмний спортын их наадмын ХБИ-ийн спортын наадамд хонхот бөмбөг, пара жүдо бөх, диф волейбол, пара хөнгөн атлетик төрөлд 30 тамирчин оролцож 2 алт, 1

мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн. Багийн дүнгээр 6-р байрт шалгарсан. Тамирчдын зардалд ХБИ-ийг дэмжих төсөл арга хэмжээний зардлаас 3,8 сая төгрөгийг санхүүжүүлсэн.

Харааны бэрхшээлтэй иргэдийн холбооны Хонхот бөмбөгийн тамирчдыг 7 хоног бүрийн Лхагва гарагт 2 цагаар бэлтгэл, сургалт дасгалжуулалтыг тогтмол хичээллүүлж байна. Нийт эрэгтэй, эмэгтэй багийн 12 тамирчин хамрагдаж байна.



2.5 Үндэсний спортыг сурталчлах арга хэмжээ

Үндэсний спортын төрлөөр аймгийн хэмжээнд өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд нийт 60 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж 7393 иргэн хамрагдсан.

Үүнээс: Үндэсний бөх өсвөр үе 15 удаагийн арга хэмжээнд 3147, насанд хүрэгчид, залуучуудын ангилалд 30 арга хэмжээнд 2294, үндэсний сурын харваа 8 арга хэмжээнд 978, шагайн харвааны төрөлд 7 удаагийн арга хэмжээнд 974 тус тус хамрагдсан байна.

Монголын жороо морины холбоотой хамтран Шүүгч бэлтгэх баруун бүсийн сургалтыг зохион байгуулж 20 хүн хамрагдлаа.

Увс аймгийн түүхт 100 жилийн ойн Үндэсний шагайн харвааны тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 400 гаруй харваачид, үндэсний сурын харваа өсвөр, насанд хүрэгчид 4 насны ангилалаар 530,0 гаруй харваачид оролцож цэц мэргэнээ сорилоо.

Үндэсний сурын спортыг орон нутагтаа хөгжүүлэх эхлэлийг тавьж 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 зурхай бүхий үндэсний сурын талбай байгуулж, ашиглалтад оруулсан. Энэ нь улсын болон бүсийн томоохон арга хэмжээг зохион байгуулах боломжтой болж байгаа юм.



2.6 Сүмдын биеийн тамирын үйл ажиллагаа

Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/101 тоот захирамжаар арга зүйчдийн бүтцийг батлуулсан. Одоогийн байдлаар Улаангом, Малчин, Хяргас, Өлгий, Өмнөговь, Сагил, Давст, Тэс сумдад орон тооны арга зүйч, Тариалан суманд гэрээт арга зүйч ажиллаж байна.

Биеийн тамирын арга зүйчтэй 8 суманд нийт спорт, биеийн тамирын 82 арга хэмжээ зохион байгуулж, 2952 иргэн хамрагдсан байна.

2.7 Сургалт, мэдээлэл

Сумдын биеийн тамирын арга зүйчдэд БТС-ын тухай хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж, иргэдийн дунд зохион байгуулах биеийн тамирын арга хэмжээний талаар чиглэл, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Аймгийн Боловсролын газартай хамтран ЕБС, СӨБ-ийн биеийн тамирын багш нарыг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 36 байгууллагын 70 гаруй багш хамрагдлаа. Тэдний дунд “Бид тамирынхан” арга хэмжээг зохион байгуулж явууллаа.

Биеийн тамирын тухай хуулийг сурталчлах, таниулах 2 удаагийн сургалтыг биеийн тамирын багш, спортын холбоод, сум байгууллагын арга зүйч нарт зохион байгуулж 85 багш, арга зүйчдийг хамруулсан.

Биеийн тамирын багш нарыг идэвхжүүлэх зорилгоор аймгийн Боловсролын газартай хамтран “Бид тамирынхан” арга хэмжээг нийт багш нарын дунд зохион байгуулж, 73 багш оролцсон.



2.8 Бие бялдрын сорил

Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нэгтгэх, цахим программд оруулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 4500 гаруй иргэдийг сорилд хамруулсан. Одоогоор цахим программд 2800 иргэний мэдээлэл шивэгдэж орсон байна.

Гүрав. Спортын хэлтсийн үйл ажиллагаа

3.1 Спортын үралдаан тэмцээн

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Биеийн тамир, спортыг дэмжих төсөл, арга хэмжээний хөтөлбөр боловсруулж Спортын холбоодоор 1 удаа, аймгийн ЗД-ын зөвлөлөөр 3 удаа хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын хурлаар батлууллаа. Төсөл, арга хэмжээний зардалд 250,0 сая төгрөгийг батлуулсан бөгөөд нийт 13 арга хэмжээний зардалд 209,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

2025 онд тус хэлтсээс УАШТ-3 , баруун бүсийн тэмцээн 2, өсвөр болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн спортын 13 төрөлд 23 удаа зохион



байгуулж, албан байгууллага, аж ахуйн нэгж, ивээн тэтгэгчид, хандилагчдын тусламжтайгаар 166 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын 8 дугаар наадмын зуны спортын 15 төрөлд 120 гаруй өсвөрийн тамирчид оролцож 4 мөнгө, 7 хүрэл медаль, өвлийн төрөлд 14 тамирчин оролцож 15 медаль хүртэж багийн дүнгээр 1 дүгээр байр, Монголын бүх ард түмнийн спортын 17 дугаар наадамд 104 тамирчин оролцож зуны төрөлд 13 медаль, Паралимпын төрөлд 4 медаль хүртсэн.

Өсвөр болон насанд хүрэгчдийн УАШТ-с 117 медаль хүртсэн байна.

Мөсөнд авиралтын ДАШТ, 100 буудалт даам, халз тулааны ДАШТ-д 3 тамирчин Алтан медаль 2, хүрэл медаль- 1 хүртсэн.

3.2 2025 онд зохион байгуулсан томоохон спортын үралдаан тэмцээнүүд:

- ✓ Хүүхэд залуусыг спортоор хичээллэх боломжийг нээх зорилгын хүрээнд Чөлөөт бөхийн U-17, U-23 ангиллын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, спортын хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээний зардлаас 32 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



Нийт 43 багийн 850 гаруй тамирчид, багш нар оролцсон. Тэмцээний үр дүнд орон нутгийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдэд 120,0 гаруй сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.

- ✓ 100 буудалт даамын ахмад тамирчин, Спортын мастер Г.Ринзааны нэрэмжит 100 буудалт даамын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Бүс бүсээс шалгарсан Шилдэг эрэгтэй 14, эмэгтэй 14 даамчин оролцсон. Тэмцээнийг аймгийн ЗДТГ, Наранбулаг сумын ЗДТГ, Монголын 100 буудалт даамын холбоо, Онцгой хүү даамын холбоо, Г.Ринзаан агсны гэр бүл, үр хүүхдүүд хамтран зохион байгууллаа.



Хөнгөн атлетикийн Олон улсын хэмжээний мастер, ахмад тамирчин Б.Батчулууны нэрэмжит “Кросс гүйлтийн өсвөр болон насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын Хөнгөн атлетикийн холбоо, Б.Батчулуун агсны шавь, гэр бүл, үр хүүхдүүдтэй хамтран зохион байгууллаа. Тэмцээнд хот хөдөөгийн 150 гарй тамирчид оролцсон байна.



- ✓ Жүдо бөхийн U-17, U-14, U-12 ангиллын баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 5 аймгийн 6 багийн 600 гаруй тамирчид, багш нар оролцсон.



- ✓ Орон нутагт шинэ тутам хөгжиж буй Байт харвааны баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймгийн Байт харвааны холбоотой хамтран зохион байгуулж, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн 60 гаруй өсвөрийн харваачид оролцсон.
- ✓ Эдгээр нь өсвөр залуу үеийнхэнд спортоор хичээллэх сэдлийг төрүүлэх, тэднээр бахархах, бие бялдраа хөгжүүлэхэд чиглэгдсэн.
- ✓ Өсвөр үе, залуучуудын дунд биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах,



3.3 Сургалт, дасгалжуулалтын талаар


 THE MINISTRY OF FINANCE
 REPUBLIC OF VIETNAM
 TAX DEPARTMENT

* Olanzapine is a Schedule II controlled substance. It is not a Schedule I controlled substance.

Матрица Уильям Вилкс (матрица) была разработана для оценки эффективности тестов. Она была разработана в 1950-х годах. Она была разработана в 1950-х годах. Она была разработана в 1950-х годах.

2. **Матрица Брайля** (на клавиатуре) – стандартная таблица для Брайля, имеет 6 столбцов – 6 символов Брайля, также можно использовать Брайль – расширенный (до 16 столбцов)

3. **Специальное устройство** (на клавиатуре) – имеет 6 столбцов – 6 символов Брайля, также можно использовать Брайль – расширенный (до 16 столбцов)

450

Алхманы Төрөг-Дамбал 2002 оны 12
дугаар сарын 1-д /дүгээр сарын 1-д/ 84
дүгнээг зургаан жилийн хамраат

УСБӨРИЙН ШИГ ШЭЭ БАГИЙН БҮРДҮҮЛЭХ
САНХҮУГУУЛХ ЖУРАМ

NOT IDENTICAL TO THE OTHER

[illegible]

АДЕР, СПОРТЫН ТӨРЛИЙГ САНДСАХ

2.1. Ойроогойи хамгаалж байгаа тусгаарын газрын хяналтыг зогсоох үйл ажиллагааг Азийн Засаг даргын тээмж тээврийн НХА Соёл Урлагийн тээвэр тусгай зохиуур зориолсон гадаад хэргийнхэн тусгаарлалт хамгаалалт хамгаалалт зориулалттай.

2.2. Озвучивание картинок для дайвинга и подводной фотографии на этом этапе проводится только тогда, когда уже имеется хотя бы одна картинка, которую можно озвучить.

2.5. *Openness*: articles found about open systems, computer networks

2. В документе указаны все действия, которые необходимо сделать, чтобы
получить доступ к файлам. Таким образом, можно сказать, что документ
является инструкцией. Ответ: инструкция.

САУЭШТ, АУА, ЭШССА-ийн эмч мэргэжилтнүүд ЕБС-ийн биеийн тамирын багш, дасгалжуулагчдад Өсвөр насны хүүхдийн физиологийн онцлог, өсвөрийн тамирчдын бэлтгэл дасгалжуулалт төлөвлөлт, бэлтгэл дасгалжуулалтын төлөвлөлтөд анализ хийх, хэт ачааллын шалтгаан, гэмтлийн дараах яаралтай авах арга хэмжээ, гэмтлийн үед болон урьдчилан сэргийлэх зорилгоор тейп боолт хийх, Спортын хоол зүй, Спортын сэтгэл зүй тамирчдын энерги хангамж булчингийн ажиллах чадвар зэрэг сэдвүүдээр сургалт хийлээ. Сургалтад шигшээ багийн болон биеийн тамирын 20 багш хамрагдлаа.



Соёл, спортын ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам-ын талаарх сургалтыг спортын холбоод, биеийн тамирын багш нар болон спортоор хичээллэгч хүүхэд багачуудад зохион байгуулж, нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 245 хүнийг хамрууллаа.

Чөлөөт бөхийн U23, U17 насны УАШТ-ний үеэр арга зүйчдийг ирүүлж тэмцээний зохион байгуулалт, шүүлтийн талаар онол, дадлагын сургалтыг зохион байгууллаа. 9 сумын арга зүйчид оролцсон.


Спорт, биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй спортын 22 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж, 89,8 сая төгрөгийн үйл ажиллагаа, уралдаан тэмцээнийг санхүүжүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 12 сарын байдлаар спортын 168 уралдаан тэмцээнд нийт 42866 гаруй, нийтийн биеийн тамирын 88 арга хэмжээнд 25384 иргэн нийт 68250 иргэн хамрагдсан байна.

Дөрөв: Байгууллага орчноо тохижуулах талаар:

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй спортын уралдаан тэмцээн, нийтийг хамарсан арга хэмжээ, соёл урлагийн үйл ажиллагаа явуулахад орчны тохижилт, таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хамт олны хүчээр, өөрийн нөөц боломжоо ашиглан байгууллага орчноо тохижууллаа.

Спортын ордоны урсгал, засвар, фитнес клуб, албан тасалгаа, бүжгийн танхим, спортын ордоны үүдний хэсгийг тохижуулж, дотоод, гадаадын жуулчид, аялагчдад байгууллага, аймаг орон нутгаа сурталчилж ажиллаа. /Зураг/



Сургалтын танхим



үүдний хэсэг



жижүүрийн тек



Спортын ордон, бөхийн Шандас клубын дулааны шугам, цэвэр усны шугам хоолойг сольж шинэчлэв.



Спортын ордоны машин орох хэсгийн талбайг цементлэж тэгшлэв.



Спортын ордоны их засварын ажлын тооцоог Өлзий Иш ХХК-аар гүйцэтгүүлэхээр санал хүргүүлж, төсвийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.

Байгууллагын болон албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын дотно болон гадна талд тохижилт, засвар үйлчилгээ хийх, зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, сургалтын танхим болон үүдний хэсэгт тохижилт хийгдлээ.

Спортын ордоны шал будах, сургалтын танхим тохижуулах, албан хаагчдын болон ОО-ын өрөөний хаалга, хана шинэчлэх, гадна тохижилт, зүлэгжүүлэлт, цэцэгжүүлэлтэд нийт 19,0 сая төгрөг, бөхийн Шандас клубын халаалт, спортын ордоны халаалт, шугам засварын ажилд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөг, нийт 49,0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Тав. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны талаар:

5.1 Байгууллагын дотоод дахь сургалт

Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох сургалт, нийгмийн баталгааны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж ажиллаа.

Төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг ажлын байрны сургалт 8, мэргэшүүлэх сургалт 14, туршлага солилцох арга хэмжээ 1, бусад сургалтад 3 нийт 26 удаагийн сургалтад хамрууллаа. Үүнд: Төрийн албаны зөвлөлийн 4:7:10, ССАЖЗЯ, БТСУХ, Аймгийн ЗДТГ, аймгийн ЭМГ, Прокурорын газар, Боловсролын газар зэрэг байгууллагуудаас дараах чиглэлээр сургалтад хамрагдлаа.

- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүй
- ✓ Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- ✓ Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалт
- ✓ Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ
- ✓ Байгууллагын соёл, багаар ажиллах ур чадвар
- ✓ Хөдөлмөрийн хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилт
- ✓ Гэр бүлийн харилцаа, бага насны хүүхдийн хоол зүй
- ✓ Жендэрийн тэгш байдал





5.2 Байгууллагаас гаднах сургалт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан “Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэний мэргэшүүлэх сургалтад мэргэжилтэн Т.Өлзийхишиг оролцсон.

Монгол улсын Төрийн Албаны Зөвлөлөөс “Бүсчилсэн хөгжил- Төрийн албаны манлайлал” баруун бүсийн зөвлөгөөнд Биеийн тамирын хэлтсийн дарга Х.Баяртуул оролцсон.

Дархан- Уул хотноо зохион байгуулагдсан биеийн тамир, спортын салбарын улсын 3 дугаар зөвлөгөөнд 11 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр амжилттай оролцсон.

Энэхүү зөвлөгөөнөөр “Биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалтын асуудал”, “Биеийн тамирын хөгжлийн асуудал”, “Спортын тэмцээн, наадам, олимпын бэлтгэл сургуулилт” сэдвээр 3 салбар хуралдаанд албан хаагчид хамрагдлаа.

ССАЖЗЯ-наас зохион байгуулсан “Залуучуудын хөгжлийн төлөөх түншлэл, салбар дундын уялдаа холбоо” чуулга уулзалтад мэргэжилтэн Г.Чулуун оролцсон.



5.3 Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хамт олон, гэр бүлийн харилцааг сайжруулах, албан хаагчдын ажлын онцлогийг үр хүүхдүүдэд нь танилцуулах, ойлгуулах чиглэлээр байгууллагын Эцэг эхийн зөвлөлийг даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллаа.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан гэр бүлийн чуулганд 1 гэр бүл, зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалтад 2 албан хаагч оролцож, байгууллагын албан хаагчдад “Өсвөр насны хүүхдийн хооллолт гэж юу вэ”? “Сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалах нь”, “Эцэг эхийн эерэг шийдлүүд” зэрэг сэдэвүүдээр сургалт зохион байгууллаа.

“Хүн бүр хүүхэд хамгаалагч” аянд байгууллагаараа нэгдэж, цахим орчинд уриалга видео, постер хэлбэрээр байршуулсан.

Мөн спортын уралдаан тэмцээний үед хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор ус цэвэршүүлэгчийг байрлуулсан.

Олон улсын гэр бүлийн өдөр, хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүл болон хүүхэд багачуудын дунд Спортын өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулсан.





Зургаа. Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр:

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй биеийн тамирын арга хэмжээний талаар орон нутгийн "МВС" телевиз, "Увсчууд" сайт, "Увс аймгийн Биеийн Тамир, Спортын Газар" фэйсбүүк хуудас, "Өглөөний дасгал, алхалт гүйлтийг эрчимжүүлье", "Увс нутгийнхан", "Увсын спортын мэдээ" пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээ, мэдээллийг түгээж ажиллаа.

Байгууллагын пэйж хуудсанд нийт 411 (цаг үеийн нөхцөл, байдал, нийтийг хамарсан арга хэмжээний тухай 88, уралдаан тэмцээний талаарх 174, бэлтгэл, сургуулилтын мэдээлэл 7, постер мэдээлэл 48, видео бичлэг 19, шейр хийсэн 75) мэдээллийг оруулж нийт 2166498 хэнд хүргэж ажилласан.

Долоо. Төсвийн хөрөнгийн зарцуулалт ил тод байдал:

2025 онд улсын тодотгосон төсвөөс 888,6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас цалин НДШ -ийн зардалд -699,0 сая төгрөг, Хангамж бараа материалын зардалд-9,9 сая төгрөг, томилолтын зардалд-0,89 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсний зардалд-7,0 сая төгрөгийг, үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас -

77,2 сая төгрөг, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих зардлаас -12,9 сая төгрөг нэг удаагийн тэтгэмжийн зардал урсгал шилжүүлэгт -1,5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс тодотголоор 684,2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд-635,2 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд – 49,0 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна. Оны эцэст халаалт дулааны зардал дээр -176,9 сая төгрөгийн өр үүссэн энэ нь төсөв татагдсантай холбоотой үүссэн өр болно.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2025 оны жил эцсийн байдлаар 21 албан байгууллага болон хувь хүмүүстэй заал ашиглалтын гэрээ, 2 хувь хүнтэй эд хөрөнгийн түрээсийн гэрээг тус тус байгуулан ажиллаж, гэрээний төлбөр болон фитнесийн танхим ашиглалтын орлого, түрээсийн нэмэлт орлогоос нийт 30,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Нийт нэмэлт орлогоос гэрээт ажилчдын цалинд 13,2 сая төгрөг, урсгал засварын зардалд-2,5 сая төгрөг, ажилчдын нийгмийн баталгаа хангах томилолтын зардалд-2,2 сая төгрөг, унааны зардалд-2,7 сая төгрөг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд-3,8 сая төгрөг бусад зардалд-3,9 сая , мэдээлэл сургалт, суртчилгааны зардалд-1,6 сая төгрөг тус тус зарцуулсан болно.

Орон нутгийн хөрөнгөөр төрийн захиргааны албан хаагчдын ОННэмэгдэл цалин хөлсөнд 7,0 сая төгрөгийн санхүүжилт олгосноос цалин НДШ-д 0,95 сая төгрөг зарцуулсан.

Засаг даргын захирамжаар дэмжих хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлаас нийт-195,7 сая төгрөгийн санхүүжилт олгож эрх шилжүүлсэнийг биеийн тамирын арга хэмжээ буюу УАШТ, ДАШТ -нд оролцох тамирчдын шигшээ тэмцээний унаа байр хоолны зардалд спортыг дэмжих хөтөлбөрөөс-184,9 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг шигшээ тэмцээнд оролцоход унааны зардал дэмжлэг болон сургалтын зардалд -8,7 сая төгрөг аялал жуулчлалыг дэмжих хөтөлбөрөөс -2,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан болно.

ТАЙЛАН БИЧСЭН: БИЕИЙН ТАМИРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Х.БАЯРТУУЛ

